

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№18/479

ШУС, НУС

2017

МҮОНТ-ИЙН ОРЧУУЛГЫН КИНОНЫ ДУУ ОРУУЛАЛТ, УР ЧАДВАРЫН АСУУДАЛД

Г.Мэндхүү*

* МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Нийгмийн ухааны салбарын Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн багш, доктор (Ph.D), дэд профессор

Түлхүүр үг: олон нийтийн телевиз, уран сайхны кино, олон ангит кино, дуу оруулалт, ам барилт, дуу оруулагч-жүжигчин

Олон нийтийн мэдээллийн хэрэгслийн системийн нэг бүрдэл хэсэг болдог телевизийг олон талаас нь судлах шаардлагатай байдаг. Телевизийн түүх, нийгэмд гүйцэтгэж байгаа үүрэг, дэлгэцийн бүтээлийн төрөл зүйлийн хөгжил, нийтлэл нэвтрүүлгийн бодлого гэх мэт олон сэдвээр гадаадын болон манай орны эрдэмтэд судалгаа хийсэн байдаг. Урлагийн олон төрөл хэлбэрийн хэв шинжийг өөртөө багтаасан, нийгмийн харилцааны өвөрмөц хэрэгсэл учраас телевизийг ийнхүү олон талаас нь судлахаас ч өөр аргагүй юм. Телевизийн нэвтрүүлгийн сүлжээнд зайлшгүй байр суурь эзэлдэг бүтээлийн нэг төрөл бол орчуулгын кино. Телевизээр үзүүлж буй гадаадын уран сайхны болон баримтат киноны орчуулга, дуу оруулагч жүжигчинд тавигдах шаардлагын тухай асуудлыг энэхүү эрдэм шинжилгээний өгүүлэлд хөндөв. Монгол Улсад анх телевиз байгуулагдахдаа долоон редакцитай

байсны нэг нь кино программын редакци юм.

Монгол Улсад үндэсний телевиз тогтмол нэвтрүүлэг дамжуулсан эхний өдөр (1967.09.27) “Ардын элч” Монголын уран сайхны киног үзүүлсэн түүхтэй. Үүнээс хэдэн өдрийн дараа “Летопись полувека” (Хагас зууны он тоолол) хэмээх ЗХУ-ын баримтат киног орчуулалгүй, орос хэлээр үзүүлж байжээ. Ийнхүү “Монгол телевиз” (хуучин нэрээр) гадаадын киног үзүүлэх болсон байна. Өдгөө ч орчуулгын кино нь манай улсын олон нийтийн болон арилжааны телевизүүдийн кино программын 80 хувийг эзэлж байна.

Орчуулгын киноны дуу оруулалт гэдэг бол нарийн түвэгтэй ажил бөгөөд орчуулагч, орчуулгын редактор, дуу оруулагч-жүжигчин, дууны найруулагч, дууны инженер гэх мэт янз бүрийн мэргэжлийн хүмүүсийн нягт хамтын ажлын үр дүнд хийгддэг. Орчуулгын киноны хувьд дуу оруулагч жүжигчний талаар онцгойлон цохон тэмдэглэх хэрэгтэй юм. Мэргэжил гэдэг бол тусгай бэлтгэл, ажлын арга туршлагын үр дүнд олж авсан онолын цогц мэдлэг, практик дадлыг эзэмшсэн хүмүүсийн хөдөлмөрийн үйл ажиллагааны тодор-

хой төрлийг илэрхийлдэг. Товчоор хэлбэл мэргэжил нь урлаг спорт, шинжлэх ухаан, техникийн тодорхой салбарын мэдлэгийг системтэй эзэмшсэн мэдлэг чадвар юм. Мэргэжил нь дотроо мэргэшилд буюу тухайн мэргэжлийн хүрээнд үйл ажиллагааны тодорхой төрөл, чиглэлд хуваагддаг¹. Орчуулгын кинонд дуу оруулагч нарын ихэнх нь жүжигчин мэргэжилтэй бөгөөд дэлгэцийн бүтээлд дуу оруулах чадвартай, энэ чиглэлээр мэргэшсэн хүмүүс юм. Манай улсад 1935 онд “Монгол кино” үйлдвэр байгуулагдсантай зэрэгцээд баримтат киноны тайлбар унших нэвтрүүлэгч, уран сайхны киноны дүрийн харилцан ярианд дуу оруулах жүжигчин гэсэн шинэ ажлын орон тоо бий болсон.

Орчуулгын кинонд ам барих (dublication, дублирование), дуу оруулах (voice over, озвучивание) зэрэг ойлголтуудыг хольж хутган нэг зүйл гэж тооцох, эсвэл эндүү ташаа ойлгох явдал түгээмэл байна. Дуу, дүрс бичлэгийн бүтээлийн (уран сайхны кино, хүүхэлдэйн кино, баримтат кино, гадаадын телевизийн нэвтрүүлэг) яриаг нэг хэлнээс нөгөө хэл рүү орчуулан жүжигчний дуу хоолойгоор амилуулахыг ам барилт гэж нэрлэнэ². Ам барилт хийхийн тулд дэлгэцийн бүтээлийг орчуулж, хянан найруулна. Дэлгэцээр гарч байгаа хүний амны хөдөлгөөн, ярианы үргэлжлэх хугацаа зэргийг харгалздаг. Заримдаа орчуулгыг хянан найруулахад зөвлөх-редактор шаардлагатай болно. Дэлгэцийн бүтээлд яригдаж байгаа шог хошин харилцан яриа, ёжлол, этгээд хэллэгийг оновчтой орчуулж, яруу найраг, шүлгийг ч чихэнд чимэгтэй буулгах хэрэгтэй юм. Үүний дараа орчуулгын мэргэжлийн дуу

оруулагч-жүжигчинд дүр хуваарилдаг бөгөөд дууны найруулагч энэ сонголтыг хийдэг. Дэлгэцийн дүрийн дуу хоолойг бүрэн илэрхийлж чадахуйц жүжигчин сонгохыг хичээдэг байна. Мөн дуу оруулагч жүжигчний нас, тухайн дүрийн онцлогийг харгалзан үздэг. Нэг хүний дүрийг нэг л хүн сонгон ам барих нь зохимжтой. Гэвч туршлагатай жүжигчин нэг киноны хэд хэдэн дүрд ам барих тохиолдол гардаг. Манай улсын телевизүүдэд ийм туршлага бий. Тухайлбал, 1990-ээд оны хоёрдугаар хагаст жүжигчин Г.Равдан, Монголын үндэсний олон нийтийн телевизийн найруулагч Н.Байгал нар хамтран “Араатны хаан арслан” бүрэн хэмжээний хүүхэлдэйн киноны бүх дүрийн дуу хоолойг амилуулжээ. Тэгвэл ОХУ-д гадаадын жүжигчний дуу хоолойг нэг л дуу оруулагч жүжигчинд даатгаж хариуцуулдаг туршлага ч бий. АНУ-ын кино жүжигчин Хью Уивингийн бүтээсэн дүрд Оросын дуу оруулагч жүжигчин Владимир Антоник ам барьдаг байна. Тэгвэл Хятадын жүжигчин Жеки Чаны бүтээсэн киног орос хэлээр дуу оруулахад “Эрмитаж” театрын жүжигчин Андрей Бархударовыг урьдаг байна.³ Ийм жишээ олныг дурдаж болох юм. Нэг жүжигчин ингэж олон дүрд хувирч ам барих нь тухайн уран бүтээлчийн авьяас, ур чадварыг сорьсон хэрэг гэдэг нь ойлгомжтой.

АНУ-ын “20th Century Fox”, “Paramount pictures”, “Walt Disney” зэрэг томоохон кино компаниуд хилийн чанадын үзэгчдэд бүтээлээ үзүүлэх зорилгоор захиалгаар орчуулга, ам барилт хийлгэхдээ дуу оруулагч жүжигчдийг өөрсдөө сонгодог байна. Жишээ нь, “Slumdog Millionaire” (Ядуусын хорооллын саятан) уран сайхны киног орос хэлнээ орчуулан,

жүжигчдээр ам бариулахдаа телешоуны хөтлөгчийн дүрд “Саятан болохыг хүсвэл” нэвтрүүлгийн орос хувилбарыг хөтөлдөг жүжигчин Дмитрий Дибровыг сонгож байв.

Харин дуу оруулалт (voice-over, озвучивание) гэдэг нь радио, телевизийн бүтээл (нэвтрүүлэг), киноны фонограммыг эцсийн хувилбараар нь бий болгож байгаа үйлдэл юм.⁴ Фонограмм нь хөгжмийн аялгуу, чимээ шуугиан-шум, яриа гэсэн үндсэн гурван хэсгээс бүрддэг. Нэр дурдсан энэ гурван бүрдэл хэсэг нь фонотека гэгддэг дуу хөгжмийн сангаас авсан, эсвэл зөвхөн тухайн бүтээлд зориулан бий болгосон дахин давтагдашгүй байж болно. Орчин үеийн бүх хөгжмийн бүтээл нь зохиогчийн эрхээр хамгаалагдсан тул хөгжмийн зохиолчид хандан тухайн дэлгэцийн бүтээлд зориулсан дахин давтагдашгүй шинэ аялгууг захиалах нь оновчтой шийдэл юм. Кино, нэвтрүүлгийн зураг авалт эхлэхээс өмнө, эсвэл эвлүүлгийн дараа ч хөгжим зохиож болно. Энэ нь тухайн хөгжмийн зохиолчийн өмнөө тавьсан зорилго, зорилтоос хамаардаг. Хөгжмийн аялгууны бичлэгийг анхан шатны эвлүүлгийн дараа хийдэг. Учир нь энэ үед тухайн аялгуу хэр удаан эгшиглэх хэрэгтэй вэ? гэдэг нь баримжаагаар тодорхойлогдсон байдаг. Орчин үед кинонд аливаа уур амьсгалыг бий болгоход чухал зүйл нь аялгуу болж байна. Жүжигчдийн харилцан ярианаас гадна дэлгэцийн бүтээлд чимээ шуугиан нэмэгдсэнээр илүү үнэмшил төрүүлдэг. Дэлгэцийн бүтээлд шаардлагатай чимээ шуугианыг зураг авалтын үед /натурт/ бичих, эсвэл дуу хөгжмийн сангаас авна. Байгальд байдаг зарим дуу чимээг өөр аргаар оруулан бий болгох туршлага хуримтлагджээ.

Кино урлагт дуу оруулах гурван технологи бий. Нэгдүгээрт, фонограмм дор, хоёрдугаарт, шууд буюу синхроноор, гуравдугаарт, зураг авалт, эвлүүлгийн дараа дуу оруулах арга. Эхний аргаар бүтээл туурвихад зураг авалтын өмнө хэрэгцээтэй дуу чимээг урьдчилан бэлтгэсэн байна. Зураг авалтын талбарт сонсогдож байгаа дуу чимээг сонсож жүжигчид тоглодог. Энэ арга нь кино концерт хийх, хөгжимт жүжиг, олон хүн оролцож байгаа бүжгийн тоглолтын зураг авалтын үед илүү тохиромжтой. Шууд буюу синхрон арга хэрэглэх үед зургийн талбарт дуу, дүрс зэрэг бичигддэг. Гэвч жүжигчний үг хэллэг, дуу хоолойны түвшин тааруухан байх, эргэн тойрны олон чимээ шуугианаас болоод сайн чанарын фонограммтай болж чаддаггүй. Харин гурав дахь аргаар бүтээл туурвихад зураг авалт дууссаны дараа тусгай студид фонограммын бичлэг хийж, эвлүүлгийн үед дуу, дүрсийг нийцүүлдэг байна. Бодит байдал дээр дэлгэцийн бүтээл туурвихдаа дээр дурдсан аргуудын аль алиныг нь хослуулан хэрэглэдэг. Зураг авалтын үед хийгддэг шууд буюу синхрон бичлэг нь “ноорог” гэж тооцогддог бөгөөд жүжигчид эвлүүлгийн дараа дуу оруулахдаа баримжаалах гол суурь болж өгдөг. Иймд шууд буюу синхрон дуу бичлэг нь найруулагч, дууны найруулагчийн шаардлага хангадаггүй. Эвлүүлгийн дараа дуу оруулахын тулд жүжигчид тусгай дуу бичлэгийн студид ирж өөрсдийн бүтээсэн дүрдээ дахин дуу оруулна. Мөн эвлүүлгийн дараах дуу оруулалтаар нэвтрүүлэгч, хөтлөгчийн тайлбарыг хийж болох юм. Эвлүүлгийн дараах дуу оруулалтад дэлгэцэд дүр бүтээсэн жүжигчин бус, өөр хүн дуу

оруулж болно. Хөгжимт-кино, дуулалт киног дуу оруулах үед дээрх практикийг түгээмэл ашигладаг.

Дээрх тайлбараас ам барих, дуу оруулах нь ялгаатай гэдэг нь тодорхой байна. Орчуулгын кинонд ам барьж, дуу оруулж байгаа жүжигчнээс дүрийнхээ сэтгэл зүйг мэдрэх; дүрийн онцлог талыг ойлгон дуу хоолойгоо өөрчлөх; киноны үйл явдалд тохируулан жүжиглэх; дэлгэцтэйгээ харьцах зэрэг ур чадвар эзэмшсэн байх шаардлагатай.

Гадаадын киног “Монголын үндэсний олон нийтийн телевиз”-ээр (хуучин нэрээр “Монгол телевиз”) үзүүлж байсан ажлын туршлагыг дараах байдлаар үечилж болох юм. Үүнд:

1. Гадаадын киног орчуулагагүй үзүүлж байсан үе

“Монгол телевиз” байгуулагдаад эхний таван жил нь гадаадын киног орчуулгагүй үзүүлэх болов. Кино эхлэхийн өмнө уг уран бүтээлийн тухай товч танилцуулга, тайлбар яриаг үзэгчдэд хүргэдэг байлаа. Тухайн үед “Монгол телевиз”-ийн дэлгэцээр гол төлөв ЗХУ-ын уран сайхны болон баримтат киног үзүүлж байсан юм.

2. Киног орчуулж, шууд эфирт “ам барьж” байсан үе

1970-аад оны нэгдүгээр хагасаас гадаадын киног орчуулж, нэвтрүүлэгч нар шууд эфирт харилцан яриаг нь уншдаг болжээ. Тухайлбал, Монгол

телевизийн нэвтрүүлэгч Ж.Батбаяр, Б.Цэенханд нар “Юрагийн өглөө” хэмээх Зөвлөлтийн дөрвөн ангитай киноны орчуулгыг уншиж байжээ. Дараа нь нэвтрүүлэгч Ж.Батбаяр, Б.Цэенханд, Б.Хишигээ, Г.Чулуунбат нар “Давхар мэх” уран сайхны кино-ны

дүрүүдэд дуу оруулсан нь анх удаа олон хоолой салгаж уншсан тохиолдол байв. 1990 оноос өмнө “Монгол телевиз”-ийн дэлгэцээр ЗХУ болон социалист системд багтаж байсан Зүүн Европын орнуудын киног зонхилон үзүүлж байв. Энэ он жилүүдэд орчуулгын кинонд дуу оруулах

ажилд нэвтрүүлэгчдээс гадна телевизийн өөр мэргэжлийн уран бүтээлчид, мөн радио, телевизэд хүүхдийн нэвтрүүлэг хөтөлж байсан ерөнхий боловсролын сургуулийн сурагчид ч оролцох болжээ. Тухайлбал 1985 оноос “Монгол телевиз”-ийн туслах найруулагч Б.Эрхэмболор, 1990-ээд оны эхэн үед “Монгол телевиз”-ийн туслах найруулагчаар ажиллаж байсан Н.Байгал, 1992 оноос МХО-ны драмын дугуйлангийн сурагч, Монголын радиогийн хүүхдийн нэвтрүүлгийн хөтөлгөч Ө.Отгонбаатар, 1993 оноос жүжигчин С.Батцэцэг, О.Оюун, 1994 оноос жүжигчин Н.Наранбаатар нар кинонд дуу оруулдаг болжээ. 1990-ээд оны “Монгол телевиз”-ийн нэвтрүүлгийн сүлжээнд ням гараг бүр 16:10 цагаас хүүхдэд зориулсан уран сайхны олон ангит киноны цагтай байсан юм.



Орчуулгын кинонд ам барьж, дуу оруулж байгаа жүжигчнээс дүрийнхээ сэтгэл зүйг мэдрэх; дүрийн онцлог талыг ойлгон дуу хоолойгоо өөрчлөх; киноны үйл явдалд тохируулан жүжиглэх; дэлгэцтэйгээ харьцах зэрэг ур чадвар эзэмшсэн байх шаардлагатай



Тухайн үед “Оддын охин”, “Нисдэг Честимер”, “Банштай зутан”, “Үлгэрийн баатрууд амилсан нь”, “Электрон жаалын адал явдал” гэх мэт Чех, Словак, Болгар, Герман, Оросын олон ангит киног орчуулж үзэгчдэд толилуулжээ. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын өвлийн амралтаар эдгээр киног давтан үзүүлж байсан. 1970-аас 1990-ээд оны эхэн үе хүртэл “Монгол телевиз”-ээр үзүүлж байгаа гадаадын уран сайхны бүх киноны орчуулгыг нь эфирт шууд уншдаг байв. Киноны харилцан яриаг шууд эфирт унших нь уран бүтээлчээс ур чадвар, авьяас, тэвчээр шаардсан хүнд хөдөлмөр юм.

3. Дуу оруулалтын шинэ технологи нэвтрүүлсэн үе

1989 оны 12 дугаар сард “Монгол телевиз”-ийн техникийн шинэ төвийн нээлт болоход гурван студийг хүлээн авсан. Энэ нь 600 м/кв талбайтай их студи, 150 м/кв талбайтай дунд студи, мөн дуу оруулах студи байв. 1989 онд дуу оруулах студийг ашиглаж эхлэх үед технологийн горимд тохиргоо сайн хийгдээгүй байсан тул дуу, дүрс нь зөрөх явдал байнга гарч байв. 1994 оноос эхлэн телевизээр үзүүлэхээр хөтөлбөрт зарлагдсан киног хувилаад, дараа нь шууд тухайн соронзон хальсанд дээр нь дуу чимээ, ярианы бичлэг хийдэг болжээ. Энэ мөчөөс хойш орчуулгын кинонд дуу оруулалтыг чанарын өндөр түвшинд хийх нөхцөл бүрдсэн юм. Хамгийн анх чанарын шаардлагад нийцүүлэн дуу оруулалт хийсэн кино нь “Али Баба ба 40 дээрэмчин” уран сайхны кино байв. Энэ кинонд нэвтрүүлэгч нар дуу оруулсан бөгөөд дууны найруулагчаар Л.Сүрэнхоролоо, Ц.Гүндэгмаа, дууны

инженер П.Цогзолмаа нар ажиллажээ. Үүний зэрэгцээ “Монгол телевиз”-ийн кино албаныхан хуучин киног сэргээн хуулах, кино архивлан хадгалах, видео киноны сантай болох ажлыг хийсэн юм.

4. Мэргэжлийн дуу оруулагч-жүжигчид ажиллаж эхэлсэн үе (1995- өнөөг хүртэл)

1995 оноос эхлэн “Монгол телевиз”-ийн кино сурталчилгааны албанд нэвтрүүлэгчдээс гадна мэргэжлийн жүжигчид ажиллах болжээ. “Монгол кино” үйлдвэрт ажиллаж байсан ахмад үеийн жүжигчин Д.Элбэгсайхан, Н.Нэргүй-баатар, Т.Цэмпэлмаа, Ж.Дарамсүрэн, Г.Равдан Т.Карма нар “Монгол телевиз”-ийн орчуулгын кинонд дуу оруулах болсон байна. Ингэснээр “Монгол кино” үйлдвэрт кинонд дуу оруулж байсан ажлын арга барил, туршлага “Монгол телевиз”-д нутагшиж, телевизийн орчуулгын киноны дуу оруулалтад ахиц дэвшил гаргажээ. Түүнчлэн “Монгол телевиз”-ийн кино сурталчилгааны албанд шинэ залуу жүжигчид ч орчуулгын кинонд дуу оруулах болж, ахмад туршлагатай дуу оруулагч-жүжигчдээс зөвлөгөө авч ажиллах болсон байна. 1990-ээд оны хоёрдугаар хагасаас “Монгол телевиз”-ийн кино программын бодлогод өөрчлөлт гарч, Монголын үзэгчид Орос төдийгүй Европ, Америк тивийн орнуудын уран сайхны киноны өв сантай танилцсан юм. 1990-ээд оны хоёрдугаар хагаст “Мятрашгүй Жулиа”, “Цэнхэр булан”, “Амьдралын хүрд”, “Хатан хаа Сиси”, “Өргөст модны шувуу”, “Бужгар үст Сью”, зэрэг киног үзүүлсэн нь үзэгчдээс өндөр үнэлэлт авсан.

1995 оноос эхлэн “Монгол телевиз”-ээр Венесуэлийн телевизийн

“Халтар царайт” олон ангит киног үзүүлсэн. Тухайн үед “Монгол телевиз”-ийн программын захиргааны албанд ажиллаж байсан сэтгүүлч Х.Наранжаргал БНХАУ-ын нийслэл Бээжин хотод зохион байгуулагдсан “Телеконтентын үзэсгэлэн яармаг”-аас “Халтар царайт” киног албан ёсны эрхтэйгээр худалдан авч байжээ. Энэ кинонд нэвтрүүлэгч Б.Уранчимэг, Б.Гантигмаа, Ш.Бямбацогт, Д.Цоодол, С.Гантөмөр, н.Баяртогтох нар дуу оруулсан юм. “Монгол телевиз”-ийн тухайн үеийн нэвтрүүлгийн сүлжээнээс харахад “174 ангитай “Халтар царайт” олон ангит киног зөвхөн бямба, ням гарагт үзүүлж байжээ. Кино үзэгчдийн сонирхолыг их татаж, дэлгүүр хоршоо хаагдаж, Улаанбаатар хотод нийтийн тээврийн хэрэгсэл түр зогсож байсан бодит түүх бий. Ерөнхий сайд П.Жасрайг хөдөө орон нутагт томилолтоор ажиллах үед нь хөдөөгийн оршин суугчид “Халтар царайт” киноны гол дүрийн талаар асууж, намрын ургац хураалтын үед киног түр завсарлахыг хүссэн албан бичгийг Засгийн Газраас телевизийн удирдлагад илгээж байсан тухай сэтгүүлч, Х.Наранжаргал телевизийн 50 жилийн ойд зориулсан баярын нэвтрүүлэгт оролцох үедээ ярьж байлаа. “Халтар царайт” олон ангит кино нь үнэхээр Монголын нийгэм, хүмүүсийн сэтгэлгээнд тодорхой хэмжээгээр нөлөөлсөн юм. 1990-ээд оны сүүл, 2000 оны эхэн үеэс Ази тивийн орнуудын кино “Монголын үндэсний телевиз”-ээр үзүүлэх болсон. Тухайлбал, “Ошин”, “Сузуран”, “Токиогийн бүсгүйчүүд” гэх мэт Японы олон ангит кино, “Анхны хайр”, “Цэцгийн хүлэмж”, “Гурван марал од”, “Төгөлдөр хуур” гэх мэт Солонгосын олон ангит киног үзүүлжээ. 2000-2010 оны хооронд орчуулгын киноны дуу оруулагчдын

хүрээ өргөжиж Л.Гантулга, Ө.Наранбаатар, С.Ганчимэг, А.Миеэгомбо, Б.Уламбаяр нарын залуу уран бүтээлчид ажиллах болжээ. Мөн 2010 оноос хойш “Монголын үндэсний олон нийтийн телевиз” бүтцийн өөрчлөлт хийж нэвтрүүлэгчдийн албыг кино албатай нэгтгэн “Уран бүтээлийн тавдугаар нэгдэл” гэж нэрлэх болов. Ингэснээр нэвтрүүлэгч Б.Баярмаа, Д.Цовоо нар орчуулгын кинонд дуу оруулдаг болсон байна. Монголын үндэсний телевиз орчуулгын кинонд дуу оруулагчдын хүрээг тэлэх, ам барих ажлын арга барилыг залууст уламжлуулан өвлүүлэхэд онцгой үүрэг гүйцэтгэж байгааг зайлшгүй цохон тэмдэглэх хэрэгтэй юм. Мэргэжлийн жүжигчдээс гадна кинонд дуу оруулах хүсэлтэй залуусыг бүртгээд богино хэмжээний сургалт зохион байгуулжээ. Эцэст нь шалгаруулалт явуулж тодорхой болзол хангасан залуу уран бүтээлчийг дуу оруулагчийн ажилд авсан туршлага ч байна.

2016 оноос хойш БНХАУ-ын Засгийн газар Торгоны замын “Нэг зам-нэг бүс” хэмээх томоохон багц ажлыг олон улсын хэмжээнд хэрэгжүүлж байна. Энэ хүрээнд Төв Азийн 20 гаруй улсад “Хятадын театр” төслийг эхэлүүлсэн. 2016 оны 10 дугаар сард Монголын үндэсний олон нийтийн телевиз, БНХАУ-ын олон улсын радио “Хятадын театр” төслийг хамтран хэрэгжүүлэх хэлэлцээр байгуулсан. Үүний дагуу 2017 оны эхний хагас жилд олон ангит кино 5, бүрэн хэмжээний уран сайхны кино хоёрыг монгол хэл рүү орчуулан дуу оруулжээ. Улмаар 2017 оны 7 дугаар сарын 8-нд энэ төслийг эхлүүлэх гэрээнд гарын үсэг зурсан байна.⁵ Төсөл хэрэгжснээр “Ухаарч амьдрах хорвоо”, “Миний жаахан нар”,

“Хүний мөс”, “Мөрдөгч Ди буюу нууцлаг гүрэн” зэрэг киног Монголын үндэсний олон нийтийн телевизийн дэлгэцээр гаргажээ. “Нэг зам нэг бүс” төслийн хүрээнд “Ухаарч амьдрах хорвоо” олон ангит киног Хятадын төв телевиз төв азийн 20 орны телевизэд нийлүүлсэн бөгөөд МҮОНТ-ийн дуу оруулагчдын ур чадвар бусад орнуудынхаас нэн сайн байгааг хятадын мэргэжилтнүүд сайшаан цохон тэмдэглэжээ.

Монголын үндэсний олон нийтийн телевизийн орчуулгын киноны хамт олон жилдээ 400 гаруй нэр төрлийн гадаад киног үзэгчдэд толилуулдаг. Энэ хамт олон Монгол Улсад орчуулгын киноны дуу оруулалтын стандартыг тогтоосон гэж дүгнэж болох юм. Бусад телевизийн кино албаныхан орчуулгын кинонд дуу оруулахдаа Монголын үндэсний олон нийтийн телевизийн жишгийг даган дуурайдаг. Телевизийн сүвгийн тоо нэмэгдэх тусам орчуулгын киноны дуу оруулагчийн эрэлт нэмэгдэж, мэргэшсэн жүжигчин бэлтгэх шаардлага зүй ёсоор амьдралаас урган гарч байна. Ийм мэргэшсэн жүжигчинг их дээд сургуулийн танхимийн сургалтаар бэлтгэх боломж туйлын хомс бөгөөд МҮОНТ-ийн орчуулгын киноны алба нь сургалтын нэг түшиц бааз болж байгааг цохон тэмдэглэх хэрэгтэй юм.

Ишлэл

- ¹ Зулькафиль М. Сэтгүүлчийн мэргэжил өчигдөр, өнөөдөр, маргааш. УБ. 2014 х.32
- ² Мэндхүү Г, Өнөрсайхан Т. Телевизийн тухай А-Я хүртэл. УБ. 2014 х.13
- ³ Как делают дубляж и озвучивание фильмов
<https://www.mirf.ru/kino/dublyazh-i-ozvuchivanie-filmov> 2017.10.20
- ⁴ Мэндхүү Г., Өнөрсайхан Т. Телевизийн тухай А-Я хүртэл. УБ.2014 х.28
- ⁵<http://mn.china-embassy.org/mn/tpxw/t1476901.htm>

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Зулькафиль М. 2014. Сэтгүүлчийн мэргэжил өчигдөр өнөөдөр маргааш. УБ.
2. Зулькафиль М. 2006. Орчин үеийн Монголын сэтгүүл зүй. УБ.
3. Мэндхүү Г., Өнөрсайхан Т. 2014. Телевизийн тухай А-Я хүртэл. УБ.
4. Монгол Улс дахь БНХАУ-ын ЭСЯ-ны сайт. <http://mn.china-embassy.org/mn>
5. Как делают дубляж и озвучивание фильмов? <https://www.mirf.ru>

Резюме

В статье рассматривается опыт дублирования зарубежных кинофильмов монгольским национальным телевидением. А также описаны основные этапы дублирования кинофильмов и сообщается о персоналах редакции кинопрограмм что, представляет историческую ценность.